

ТОГТООЛЫН ТӨСӨЛ

Тэмдэгтийн хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 29.1.12, 35.1.4-35.1.22 дахь заалт, 35.2-35.5 дахь хэсэгт заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг шинэчлэн хавсралтаар тогтоосугай.

2.Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоосон хуваарь, ногдуулах ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхбаатар)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, Хууль зүй Дотоод хэргийн яаманд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ч.Жавзанпагам)-д даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 9-р хуралдааны 07 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ц.ЖАМБАЛСҮРЭН

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны дугаар сарын-ны өдрийндугаар
Хуралдааныдугаар тогтоолын хавсралт

д/д	Тэмдэгтийн хураамжийн төрөл	Тэмдэгтийн хураамжийн хэмжээ
1	Улсын тусгай хамгаалалттай газар нутгаас бусад газарт байрлах отоглох цэгээр үйлчлүүлэхэд нэг хүн	10.000 төгрөг
	Нэг автомашин	10.000 төгрөг
2	Агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход	1.000.000 төгрөг
3	Тамхи худалдах зөвшөөрөл олгоход	500.000 төгрөг
4	Ус хэрэглэгчид газрын доорх ус ашиглалтын цооног өрөмдөх тусгай зөвшөөрөл олгоход	480.000 төгрөг
5	Ус ашиглагчтай гэрээ байгуулж, 100 шоо метрээс бага ус ашиглуулах гэрчилгээ олгоход гэрээний жил тутамд	160.000 төгрөг
	гэрээг сунгахад	100.000 төгрөг
6	Усны барилга байгууламж гэрээгээр эзэмших, ашиглах эрх олгох, эрх сунгахад	200.000 төгрөг
7	Ан амьтныг эзэмших зөвшөөрөл олгоход	240.000 төгрөг
8	Нэн ховор, ховор амьтныг судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, гоо зүйн зориулалтаар /ажиглаж судлах, тэмдэг тавих, зурах, зураг авах зэрэг хэлбэрээр/ амьтныг гэмтээлгүйгээр амьдрах орчныг нь алдагдуулалгүйгээр ашиглах зөвшөөрөл олгоход	200.000 төгрөг
9	Хөрс бүрдүүлэх, байгалийг ариутгах, ургамалд тоос хүртээх зэрэгт амьтны амьдралын үйл ажиллагааны хэрэгтэй чанарыг ашиглахдаа амьтанд гэмтэл учруулахгүйгээр гүйцэтгэх ба ийм хэлбэрээр амьтныг ашиглах зөвшөөрлийг олгоход	40.000 төгрөг
10	Ан амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, хуулийн этгээдэд суман дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт олгоход	10.000 төгрөг
11	Үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын ан амьтан агнах, барих гэрээ байгуулахад	2000.000 төгрөг
12	Ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход килограмм тутамд	6000 төгрөг
13	Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах тусгай зөвшөөрөл олгоход	4000 төгрөг
14	Элбэг ургамлыг гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд түүж бэлтгэхэд нойтон жингийн килограмм тутамд	20000 төгрөг
15	Ойн дагалт баялгийн нөөцийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах тусгай зөвшөөрөл олгоход	0-10 килограмм бол 4000 төгрөг 10 килограммаас дээш бол 10 килограммаас дээш тооцсон хэмжээний килограмм тутамд 200 төгрөг нэмж

16	Малын удам гарвальный болон эрүүл мэндийн гэрчилгээ, шилжилт хөдөлгөөний тодорхойлолт, мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ эрхлэх итгэмжлэлийн гэрчилгээ, мал, үржүүлгийн бүтээгдэхүүний гарал үүслийн тодорхойлолт, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарын гэрчилгээ олгоход		10.000 төгрөг
17	Рашаан ашиглах, савлах зөвшөөрөл олгоход		640.000 төгрөг
18	Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход	аймгийн төвийн суманд	1.000.000 төгрөг
		бусад суманд	500.000 төгрөг
	Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад	аймгийн төвийн суманд	300.000 төгрөг
		бусад суманд	200.000 төгрөг
19	11.00-22.00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход	аймгийн төвийн суманд	500.000 төгрөг
		бусад суманд	300.000 төгрөг
	Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад	аймгийн төвийн суманд	300.000 төгрөг
		бусад суманд	100.000 төгрөг
20	14.00-04.00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход	аймгийн төвийн суманд 500.000 төгрөг	1.500.000 төгрөг
		бусад суманд 300.000 төгрөг	900.000 төгрөг
21	Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход		100.000 төгрөг
22	Мод, модон түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээ олгоход	6м3 хүртэл	3000 төгрөг
		6-10м3 хүртэл	4500 төгрөг
		10-20м3 хүртэл	6000 төгрөг
		20-60м3 хүртэл	15000 төгрөг
23	Ойгоос хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичиг олгоход:	8м3 хүртэл	4500 төгрөг
		8-10м3 хүртэл	6000 төгрөг
		10-20м3 хүртэл	10500 төгрөг
		20-30м3 хүртэл	15000 төгрөг
24	Ойгоос түлээ бэлтгэх эрхийн бичиг олгоход	0-10м3	3000 төгрөг
		10-20м3	3600 төгрөг
		20-30м3	4500 төгрөг
25	Арчилгаа, цэвэрлэгээний журмаар бэлтгэсэн модонд гарал үүслийн гэрчилгээ олгоход	0-10 куб метр бол	2000 төгрөг
		10 куб метрээс дээш бол 2000 төгрөг дээр 10-аас дээш сийрэг куб метр тутамд	150 төгрөг нэмж
26	Ойгоос бэлтгэсэн гуалин, шургааг, дүнз, зүсмэл материалыг өөр аймаг, сум, хот, суурингийн хооронд тээвэрлэх, худалдах, мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ олгоход	0-10 куб метр бол	2000 төгрөг
		10 куб метрээс дээш бол 2000 төгрөг дээр 10-аас дээш куб метр тутамд	150 төгрөг нэмж